

**“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 02 дугаар сарын 24 өдөр

дугаар 0/

Улаанбаатар хот

“Блюскай Секьюритиз ҮЦК” ХК-ний Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 02 дүгээр сарын 24-ний өдрийн 12 цаг 10 минутанд Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Худалдааны гудамж, Дельта төвийн 5-р давхарт 502 тоот өрөөнд эхлэв.

Хуралд 583008 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч Г.Оюунболд, Г.Намхайдорж, У.Анар нарын 3 хувьцаа эзэмшигчид биечлэн оролцсон бөгөөд энэ нь нийт саналын 69,9 хувь болж байгааг тооллогын комиссын дарга хурал зохион байгуулах комисс болон хувьцаа эзэмшигч нарт мэдэгдэж, хурал хүчин төгөлдөрт тооцох тухай тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулснаар хурал эхлэв.

Хурлын дарга Г.Оюунболд эхлээд хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.Үүнд :

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
3. Компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах
4. Ногдол ашиг хувиарлах эсэх тухай тайлагнах
5. Бусад.

Гүйцэтгэх Захирал У.Анар:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Компани тусгай зөвшөөрлөө сэргээлгэн үйл ажиллагаагаа тогтвортой явуулсан жил байлаа. Брокерийн үйл ажиллагааны хүрээнд 50 гаруй иргэдэд үнэт цаасны данс нээж үйлчилгээ үзүүлсэн. 2022 онд компани нь маржин арилжааны үйлчилгээг нэвтрүүлсэн бөгөөд үүний хүрээнд мөнгө угаалт, терроризмтой тэмцэх дотоод журмыг Санхүүгийн Зохицуулах Хороо, Монгол банкны дүрэм журмын дагуу шинэчлэн найруулсан.

Мөн компани Хөрөнгө оруулалтын зөвлөх, Гадаад улсын үнэт цаасны арилжаанд зуучлах нэмэлт зөвшөөрөл авах хүсэлтээ Санхүүгийн Зохицуулах Хороонд өгсөн бөгөөд СЗХ-ноос зөвшөөрлөө хүлээж байна. 2022 оны 3 сарын 9 өдрийн СЗХ-ын 100-р тогтоолоор компанийн хаалттай хүрээд гаргасан нэмэлт хувьцааг бүртгэхийг зөвшөөрсөн болно. Ингэснээр компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 780 сая төгрөгөөр нэмэгдэж өөрийн хөрөнгө 500 орчим сая төгрөгөөр нэмэгдсэн. Бид цаашид гадаад хувьцааны арилжааны брокерийн үйл ажиллагаа явуулахаар төлөвлөөд байна.

Та бүхэн имэйлээр явуулсан санхүүгийн тайлантай танилцсан гэж бодож байна. Мөн одоо асуух зүйл байвал асуугаарай.

Хувьцаа эзэмшигчид: Байхгүй

Хурлын дарга Г.Оюунболд : Хэлэлцэх асуудлын дараагийн зүйл Компанийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг та бүхэнд хэвлэмэл бйадлаар тараасан байгаа.

Хувьцаа эзэмшигчид бүгд дэмжиж батлав.

Хурлын дарга Г.Оюунболд : Компанийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа хэдий ч ашигтай ажиллаж чадахгүй байгаа учир хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэнийг танилцуулав. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах болон нэмж үйл ажиллагааны чиглэлд хөрөнгө оруулалтын зөвлөх, гадаад хувьцаанд зуучлах эрх, андеррайтерийн эрх авах тухай танилцуулав.Энэ зах зээлд цаашид ашигтай ажиллахын тулд андеррайтерийн эрх авах зайлшгүй шаардлагатай байна. Их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцэл хийгдэх шаардлагатай тохиолдолд ТУЗ бүрэн эрхийнхээ хүрээнд хийх эрхтэй.

Хувьцаа эзэмшигчид бүгд санал нэгтэй зөвшөөрч, бид энэ тусгай зөвшөөрлийг авах хэрэгтэй. Холбогдох дүрэм журам, төлөвлөгөө зэргийг батлах эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрхэд хамааруулан үлдээж байна гэв.

Дараагийн бусад гэх асуудлын хрээнд “Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох” тухай хэлэлцье. Төлөөлөн Удирдах Зөвлөлд түр томилогдсон гурван гишүүн байгаа тул ТУЗ-ийн гишүүдээ шинээр сонгох шаардлагатай гэж бодож байна.Гишүүдийн танилцуулгыг та бүхэнд танилцуулж байна. Та бүхэн шинэ гишүүдийн анкет болон товч танилцуулгаас харна уу. Гишүүдийг ТУЗ-ийн гишүүнээр сонгоход санал нэг байгаа нь саналын хуудсан дээрээ бичээрэй.

Хувьцаа эзэмшигчид: Татгалзах зүйлгүй. Дэмжиж байна.

Гүйцэтгэх Захирал У.Анар: Бусад асуудлын хүрээнд мөн компанийн хэлбэр өөрчлөх, нэмэлт хувьцаа гаргах, тэргүүн ээлжинд хувьцаа эзэмшүүлэх эрх эдлүүлэх эсэх, шаардах эрх хэрэгжүүлэх зэрэг асуудлыг хэлэлцэх шаардлагатай байна.

Компанийн үйл ажиллагааны чиглэлд хөрөнгө оруулалтын зөвлөх, гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа болон андеррайтерийн үйл ажиллагааг нэмж авах гэж байгаа тул хувьцаат компани учраас хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай болно. Үүнийг нэмэлт хувьцаа гаргах замаар нэмэгдүүлэх ёстой.

Гурван тэрбум хүртэлх төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцаа нэмж гаргах, нэмж хувьцаа гаргах гэж байгаатай холбоотойгоор одоогийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжид хувьцаа худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэх саналтай байна. Мөн манай компанийн нэрийг харуул хамгаалалтын компанитай андуурах явдал их байгаа тул нэр өөрчлөх саналтай байна. Компанийн оноосон нэрийг хавсралтад дурдсан нэрийн баталгаажуулалтын хуудсанд бичигдсэнээр өөрчилөх хэрэгтэй байх. Нэрийн баталгаажуулалтын хуудас нь 1 сарын хугацаатай байдаг тул дахин дахин өөрчлөгдхөд хүрдэг бэрхшээл байна. Тиймээс нэрийн баталгаажуулалтын хуудас гээд байгаа юм.

Андеррайтер, хувьцаа нэмж гаргахтай холбоотой үнэ тогтоох, холбогдох төлөвлөгөө, дүгнэлтүүдийг батлах, шаардах эрх хэрэгжүүлэх эрхийг компанийн ТУЗ-д олгох саналтай байна.

Хурлын дарга Г.Оюунболд: Тус компани нь үйл ажиллагаагаа өргөжүүлэн тусгай зөвшөөрөл нэмж авах, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангахаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх бүрт хувьцаат компани тул нэмэлт хувьцаа гаргах шаардлагатай байгаа нь зардал ихтэй бас зөвшөөрөл авахад маш их цаг хугацаа алдаж байгаа тул тус компанийг хувааж компанийн хэлбэрийг өөрчлөх саналтай байна.

Компанийг хуваахтай холбоотой үнэ тогтоох, холбогдох төлөвлөгөө, дүгнэлт, хуваах баланс батлах, шаардах эрх хэрэгжүүлэх зэрэг компанийг өөрчлөн байгуулах эрхийг компанийн ТУЗ-д олгох нь зүйтэй байх.

Хувьцаа эзэмшигчид: Санал нэгтэй дэмжиж байна. Хувьцаа эзэмшигчдээс өөр санал, асуулт гараагүй тул санал хураалтыг эхлэв.

Саналын хуудсыг тооллогын комисст хүлээлгэн өгсөний дараа хурлын дарга Хувьцаа эзэмшигчдэд хурлын шийдвэрийн төслийг танилцуулав.

Тооллогын комиссын дүнг тооллогын комиссын дарга танилцуулав.

Санал хураалтанд хуралд оролцогчид 100% оролцож, нийт саналын хуудас дахь асуулгыг 100% дэмжсэн байна. Хүчингүй саналын хуудас гараагүй.

“ Блюскай Секьюритиз ҮЦК ” ХК-ийн 2023 оны 2-р сарын 24 өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлын дагуу **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэж хангалттай гэж дүгнэлээ.
2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хурлаар хэлэлцэгдсэнээр баталж, холбогдох төсөл боловсруулахыг даалгав.
3. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрөв.
4. Ногдол ашиг хувиарлахгүй тухай тайлагнав.
5. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгов.
6. Бусад /компанийн хэлбэр өөрчлөх, нэмэлт хувьцаа гаргах, тэргүүн ээлжинд хувьцаа эзэмшүүлэх эрх эдлүүлэх эсэх, шаардах эрх, ТУЗ-ийн гишүүн сонгох/ батлав.

Хурлын дарга Г.Оюунболд:– Энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал үүгээр өндөрлөж байна. Хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд амжилт хүсье. Баярлалаа.

“ Блюскай Секьюритиз ҮЦК ” ХК – ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 15 цаг 10 минутад дуусав.

Хурлын дарга

Тэмдэглэл хөтөлсөн:



Г.Оюунболд

Л.Дөлгөөн